

**ХЭНТИЙ АЙМГИЙН УЦУОШТ-ИЙН УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ ТЕХНОЛОГИЧ
ИНЖЕНЕР АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ**

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтын боловсруулсан үндэслэл:

- Байгууллагын бүтэц, орон тоо шинэчлэгдсэн.
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

"Аймаг, хотын ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дүрэм, бүтэц орон тооны хязгаарыг батлах тухай" ЦУОШГ-ын А/162 дугаар тушаал

Дагаж мөрдөх огноо:

2025. 09. 01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2025. 08. 13

Байгууллагын нэр:

Хэнтий аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв

Нэгжийн нэр:

Урьдчилан мэдээлэх салбар

Албан тушаалын нэр:

Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга бөгөөд урьдчилан мэдээлэхийн технологич инженер

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Төрийн үйлчилгээний мэргэжил ангилал, ТҮМ-6

Ажлын цаг:

байршил:

Өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 2-р баг Тэмүүжингийн гудамж Н-13

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Онцгой нөхцөл: Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлийн үед илүү цагаар ажиллана.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Ус цаг уур орчны төлөв байдлын өөрчлөлтийн мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг хангаж, байгаль цаг агаарын болзошгүй гамшгийн эрсдэлээс сэргийлэх ажлыг зохион байгуулан, цаг уурын мэдээлэл үйлчилгээний ажлын чанар, үр дүнг хариуцан ажиллахад оршино.

Албан тушаалын зорилт

1. Монгол улсын хууль тогтоомж, Монгол улсын урт, богино, дунд хугацааны хөгжлийн бодлогын төлөвлөлт, Ус цаг уур орчны хяналт шинжилгээний тухай төрийн бодлого, төлөвлөлт, Засгийн газар, аймаг, орон нутгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах
2. Ус, цаг уур, орчны бүх төрлийн мэдээ мэдээллийг нэр төрлөөр нь тогтоосон хугацаанд чанартай зохиож хэрэглэгчдийг ханган байгаль цаг уурын гаралтай гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх
3. Цаг уурын холбоо, сүлжээ, мэдээлэл солилцоо, үйлчилгээний ажлын технологийн мөрдөлт, хэмжлийн нэгдмэл байдалд хяналт тавих
4. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй салбар, үйлчилгээг цаг агаарын тусгай хэрэгцээний мэдээллээр хангах
5. Ус цаг уур орчны мэдээллийн дэд сангийн бүрдүүлэлт, үйл ажиллагаанд хяналт тавих
6. Цаг агаарын урьдчилсан мэдээний таарц, ончийг сайжруулах, гамшигт үзэгдлийн талаарх судалгаа хийж, дүгнэлт гаргах
7. Инженер, мэргэжилтэн, албан хаагчдын мэргэжил, мэргэшил, мэдлэг, дадлага, туршлагыг дээшлүүлэх
8. Мэдээлэл үйлчилгээний хэлтсийг өдөр тутмын удирдлагаар хангаж ажиллах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд:	Монгол Улсын хууль, Засгийн газар, БОАЖЯ, ЦУОШГ-аас цаг уурын мэдээлэл, үйлчилгээний ажлын талаар гарсан тогтоол, тушаал, хөтөлбөр, удирдамж, журам, дүрэм, бусад байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг судлан хэрэгжилтийг зохион байгуулна.	Гүйцэтгэл хувиар	Г, Х, Ш, Т
	Дэлхийн цаг уурын байгууллага /ДЦУБ/-ын зөвлөмж, Монгол улсын ус, цаг уур орчны мэдээлэл үйлчилгээний ажлын хөтөлбөрийн биелэлтийг хангах, гүйцэтгэлийг нэгтгэн үнэлэх	Хэрэгжилт, хувиар	

	Засаг даргын мөрийн хөтөлбөр, Хэнтий аймгийн урт болон дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд тусгагдсан ажил үүргийн биелэлтийг хангах	Хэрэгжилт, хувиар	Г,Х,Ш
	Хэлтсийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөж биелэлтийг тооцох, тайлагнах	Төлөвлөгөөний биелэлт, хувиар	Г,Х,Ш
	Салбарын үйл ажиллагаатай холбоотой хугацаатай бичгийн хариу өгөх, гэрээ дүгнэх, тайлан мэдээг заасан хугацаанд явуулах, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах	Баримт бичгийн эргэлтийг сайжруулж, тогтоосон цаг хугацаанд хүргүүлсэн байх	Г,Х,Ш
	Мэдээлэл үйлчилгээний ажлын талаар бусад байгууллага, хувь хүмүүсээс тавьсан санал, хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авч шуурхай барагдуулах	Гомдол, саналыг бүрэн барагдуулсан байх	Г, Ш
	Онцгой үед ажиллах төлөвлөгөө журмын хэрэгжилтэнд хяналт тавих	Төлөвлөгөөний биелэлт -100%	Г,Х,Ш
	"Байгууллагын архивын журам", "Албан хэрэг хөтлөлтийн журам" – ын хэрэгжилтийг хангаж ажиллах	Хэрэгжилт хувиар	Г
2 дугаар зорилтын хүрээнд	Цаг агаарын бүх төрлийн урьдчилсан, сэргийлэх, сэрэмжлүүлэх мэдээг үнэн зөв үнэлж нэр төрлөөр тогтсон хугацаанд нь гаргах ажлыг удирдах, хянах	Мэдээний таарц улсын дундаж хувиас дээгүүр үнэлгээтэй байна.	Г,Х,Ш,Т
	Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээг зохиох ажлыг удирдах, хянах	Мэдээний онч, таарц улсын дундаж түвшингээс дээгүүр байна.	Г,Х,Ш,Т
	Цаг агаарын урт хугацааны буюу сар, улирлын төлвийг нарийвчлан зохиох ажлыг удирдах, хянах	Мэдээг тогтоосон цаг хугацаанд зохиосон байх	Г,Х,Ш,Т
	Орон нутгийн удирдлагууд, аймгийн онцгой комиссын гишүүд, ОБГ, ХХААГ-ын удирдлагуудыг үнэн зөв мэдээллээр тухай бүр шуурхай хангах	Мэдээллээр тасалдалгүй хангасан байх	Г,Ш

	Цаг агаарын урьдчилсан, сэрэмжлүүлэх, сэргийлэх мэдээг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, техник, технологийн шийдэл ашиглан хэрэглэгчдэд өдөр бүр үйлчлэх	Сум багын түвшинд хүргэж ажиллах	Г,Х,Т,Ш
	Цаг агаарын бүх төрлийн мэдээллээр удирдлага, мэргэжлийн байгууллагуудыг хангах, мэргэжил аргазүйн туслалцаа үзүүлэх	Хариу арга хэмжээ авч болохуйц хугацааны өмнө мэдээллийг хүргэсэн байх	Г,Х,Ш,Т
3 дугаар зорилтын хүрээнд:	Ус, Цаг уур орчны бүх төрлийн мэдээ дамжуулах, хүлээн авах ажлын техник, тоног төхөөрөмжийн хэвийн тасралтгүй ажиллагааг хангах	Тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангасан байх	Г,Х,Ш
	Цаг агаарын бүх төрлийн мэдээ, мэдээллийг хүлээн авах, дамжуулах ажилд байнгын хяналт тавих	Мэдээний тасалдал, хоцрогдолгүй ажиллах	Г,Х,Ш
	Синоптикийн зураг, мэдээний бүрэн байдал, цаг агаарын мэдээ гаргах технологийн мөрдөлтөнд хяналт тавина.	Технологийн зөрчил гаргалгүй ажилласан байх	Г,Х,Ш
	Цаг уурын өртөө, харуулын шуурхай мэдээний чанар, ирцийг сар бүр дүгнэж, хариу зааварчилгаа өгч ажиллах	Салбаруудын мэдээлэл үйлчилгээний ажлын чанар, ирц дээшилсэн байх	Г,Х,Ш
	Цаг агаарын мэдээ гаргах технологи, арга зүйг мөрдөх, боловсронгуй болгоход тогтмол анхаарч ажиллах, тоон прогнозын аргуудыг хэрэглэх, турших. Мэдээний хэллэг нарийвчлал, таарцыг сайжруулах, санаачлага гаргах	Мэдээний таарц сайжирсан байх	Г,Ш
4 дүгээр зорилтын хүрээнд:	Аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй агаарын хөлөгт үйлчлэх цаг агаарын бүх төрлийн мэдээний хангалт, чанарт хяналт тавих	Нислэгийн цаг уурын үйлчилгээний чанар "Хангалттай" үнэлгээнд байх	Х,Ш,Т
	Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, мэдээллээр хангах, судалгаа, дүгнэлт, тайлан мэдээ гаргах ажилд хяналт тавих, оролцох	ЦАЗНЭ-ийн үйл ажиллагааны үр дүн нэмэгдсэн байх	Г,Х,Ш,Т

	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг тусгай хэрэгцээний мэдээллээр хангах /урьдчилсан, бодит/	Мэдээлээр бүрэн хангасан байх	Г,Х,Ш,Т
	Тусгай хэрэгцээний мэдээгээр үйлчлэх хүрээг өргөжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах	Хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлсэн байх	Г,Х,Ш,Т
5 дугаар зорилтын хүрээнд:	Мэдээллийн дэд сангийн жилийн ажлын төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавих	МДС-ийн ажлын дүн хувиар	Х
	Байгууллагын баримт нягтлан шалгах комиссыг ахлан дүрэм журмын дагуу гүйцэтгэх	Жилд 2 удаа хуралдаж хуралдааны шийдвэрийн биелэлт 100% байх	Г,Х,Ш
	Байгууллагын мэргэжлийн архивын өрөө, тасалгаа, тоног төхөрөөмжийг сайжруулж, техник, технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	MNS:6929-2:2021 стандаотыг хангасан байх	Г,Х
	Шинжилгээний ажлын материалыг архивд заавар дүрмийн дагуу хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах, хадгалалт, ашиглалтанд хяналт тавих, сайжруулах	БНШК-ийн шийдвэрийн дагуу хүлээлгэн өгсөн байна.	Г,Х
6 дугаар зорилтын хүрээнд:	Байгаль, цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдлийн хохирлын мэдээг ОБГ-тай хамтран гаргаж мэдээлэх	Хохирлыг мэдээг үнэн зөв тодорхойлох нөхцлийг бүрдүүлсэн байх	Г,Х,Ш
	Цаг агаарын урьдчилсан мэдээний таарц, ончийг дүгнэх, судалгаа хийх	Таарц, ончийг өдөр бүр дүгнэсэн байх	Г,Х,Ш,Т
	Бүс нутгийн уур амьсгалын нөхцлийг тодорхойлох, гамшигт үзэгдлийн талаар судалгаа, дүгнэлт гаргах	Жил бүр хийгдсэн байх	Г,Х,Ш,Т
	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх	Жил бүр 1-ээс доошгүй сэдвээр гүйцэтгэсэн байх	Г,Х,Ш,Т
7 дугаар зорилтын хүрээнд:	Цаг уурын мэдээлэл үйлчилгээ, мэдээлэл, дамжуулах, хүлээн авах ажилд үр өгөөжтэй шинэ техник, технологийг ашиглах, нэвтрүүлэх	ЦУ-ын үйлчилгээний үр өгөөж дээшилсэн байх	Г, Х,Ш
	Салбарын инженер, мэргэжилтнүүдийн мэргэшлийн ур чадвар, зэрэг дэвийг сайжруулах	Албан хаагчид мэргэшлийн зэрэг хамгаалсан байх	Г,Т

	Инженер, техникийн албан хаагчдын мэргэшлийн ур чадварыг сайжруулах ажлыг зохион байгуулах	Инженерүүдийн таарц 98%-иас дээш байх	Г, Х,Ш
	Цаг уур, орчны шинжилгээний газар болон бусад газраас зохион байгуулах сургалт, семинарт инженер, техникчдийг хамруулах	Бүрэн хамруулсан байх	Г, Х,Ш
	Цаг агаарын урьдчилсан мэдээ гаргах аргуудыг хэрэглэх, турших	Мэдээний таарцыг сайжруулсан байх	Г,Т
	Мэдээний хэллэг, дүрс, нарийвчлал, таарц,ончийг сайжруулах санаачилга гаргах	Мэдээний чанар, өнгө үзэмжийг байнга сайжруулсан байх	Г,Т
	Таараагүй мэдээнд задлан шинжилгээ хийж, алдаанаасаа суралцах	Таараагүй мэдээний тоо буурсан байх	Г,Х,Ш,Т
8 дугаар зорилтын хүрээнд:	Дээд байгууллага, удирдлагын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж тайлагнах	Үүрэг даалгаврын биелэлт-100%	Г,Х,Ш,Т
	Хэлтсийн албан хаагч бүртэй гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж биелэлтийг дүгнэх	Зөв оновчтой төлөвлөлт хийсэн байх	Г,Х,Ш,Т
	Хэлтсийн инженер техникийн ажилтан, улсын сүлжээний техникч нарын ажлын үр дүнг сар, жилээр дүгнэж урамшуулах, хариуцлага тооцох саналыг байгууллагын дарга, даргын зөвлөлд гарган шийдвэрлүүлнэ.	Хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэгдсэн байх	Г, Х,Ш
	Хэлтсийн албан хаагчдын хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн асуудалд анхаарч ажиллах	Ажиллах нөхцөл сайжирсан байх	Г, Х,Ш
	Төрийн албан хаагчийн ёсзүй, үйлчилгээний стандартыг баримтлан, үлгэрлэн, манлайлах, өдөр тутмын хяналтыг тавих	Мөрдлөг болгон ажилласан байх	Г, Х,Ш
	Байгууллага, хамт олны саналаар зөвлөл, ажлын хэсэгт сонгогдон ажиллах	Зөвлөл, ажлын хэсгийг удирдах болон гишүүнээр ажилласан байх	Г, Х,Ш

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх
Мэргэжил	Цаг уурын инженер D0664 Цаг уурын мэдээлэл,прогноз D0666
Мэргэшил	Урьдчилан мэдээлэх инженерээр мэргэшсэн байх

Туршлага	Цаг уурын инженер, урьдчилан мэдээлэхийн инженерээр 3-аас доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> • Байгууллагын болон нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэлийг үнэлэх • Байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> • Судалгааны дүнд тулгуурлан салбарын хөгжлийн зорилтыг тодорхойлох • Тоон мэдээлэлтэй ажиллах, нэгтгэн дүгнэх
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> • Хуульд нийцсэн шийдвэр гаргах • Шийдвэрийн төслийн шууд ба шууд бус үр дагаврыг үнэлж шийдвэрийн хувилбарын талаар зөвлөх
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> • Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах • Ёс зүйгээр бусдыг манлайлан үлгэр дууриал үзүүлэх
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> • Албан хаагчдын санал бодлыг сонсож, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих • Албан хаагч бүртэй тэгш хүртээмжтэй харилцах, ажиллах
	Бусад	<ul style="list-style-type: none"> • Албан хэрэг хөтлөх, боловсруулах чадвартай байх • Комьпютерийн өргөн хэрэглээний болон салбарын үйл ажиллагаанд ашиглагддаг программ, технологиудыг ашигладаг байх • Англи хэл эсвэл бусад гадаад хэлнээс мэргэжлийн дагуух эх сурвалж, мэдээллийг ашигладаг байх

IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: УЦУОШТөвийн дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: - Урьдчилан мэдээлэх инженерүүд -4 - Систем сүлжээ хариуцсан мэргэжилтэн -1 - ЦАЗНЭ-ийн үйлчилгээ хариуцсан инженер, техникч -2 - Нисэхийн цаг уурын ажиглагч -1	Бусад харилцах субъект: <ul style="list-style-type: none"> • Цаг уур, орчны шинжилгээний газар Урьдчилан мэдээлэх хэлтэс • Газрын харьяа мэргэжлийн байгууллагууд /УЦУОСМХ, НЦУТ/ • Нисэх буудал Шууд бус харилцах байгууллага:

-Цаг уурын өртөөний инженер-8 -Өртөө, харуулын техникчид -42 Нийт: 58	Ус цаг уур, орчны шинжилгээний мэдээллийг хэрэглэгч төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд
---	--

Ү. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаалын нэр: <u>Албан тушаал:</u> <i>Аурийн ноогцлын эмч-тан</i> <i>С. Аялсан</i> (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) <i>2025 оны 2 дугаар сарын 13 -ны өдөр</i>	<u>Байгууллагын нэр:</u> <i>УТЭОУМТОВ</i> <u>Шийдвэрийн огноо:</u> <i>2025.08.13</i> <u>Дугаар:</u> <i>6/74</i>
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
<u>Байгууллагын нэр:</u> ХЭНТИЙ АЙМГИЙН УЦУОШТ	
<u>Шийдвэрийн огноо:</u> <i>2025.08.13</i>	
<u>Дугаар:</u>
(тамга/тэмдэг) (Гарын үсэг) <i>[Signature]</i>	Б.ХЭРЛЭНЧИМЭГ (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) <i>2025 оны 2 дугаар сарын 13 -ны өдөр</i>
Танилцсан.....